



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 11 сарын 03 өдөр

Дугаар 574

Улаанбаатар хот

Хөрөнгө данснаас хасч, залруулга хийх  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 22,275,540.02 (хорин хоёр сая хоёр зуун далан таван мянга таван зуун дөчин төгрөг хоёр мөнгө) балансын үнэ бүхий Дархан-Уул аймаг, Дархан сумын 14 дүгээр баг, 33 дугаар байрны 241 тоот 3 өрөө байрыг Дархан-Уул аймаг дахь сум дундын анхан шатны Шүүхийн тамгын газрын үндсэн хөрөнгөд давхар бүртгэснийг залруулан данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Дархан-Уул аймаг дахь сум дундын анхан шатны Шүүхийн тамгын газрын дарга Б.Бат-Амгаланд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгийн дансны залруулга хийх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу хийх;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах.

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.Нарангэрэл

Д.НАРАНГЭРЭЛ